



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 18 өдөр

Дугаар А/544

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Аялал жуулчлалын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1, 23.1.7, 23.1.11 Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны ээлжит XXIII хуралдааны 04 дугаар тогтоол, Аймгийн Засаг даргын 2023 оны А/682 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас 2023-2025 оны Монголд Зочлох жил болгон зарласантай холбогдуулан гадаадын болон дотоодын аялагч жуулчдад орон нутгийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлах зорилгоор “Ай Ти Эм” олон Улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцоход 5.000.000 (Таван сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх 5.000.000 (Таван сая) төгрөгийг Засаг даргын Тамгын Газрын төсөвт батлагдсан “Эрх зүй нийгмийн хэв журмын хөтөлбөр”-ийн “Засаг даргад хуулиар олгосон үүрэг, эрх хэмжээний хүрээнд захиран зарцуулах, мөн мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах” арга хэмжээний зардал”-аас гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Э.Улам-Өсөх), нягтлан бодогч (Э.Анхцэцэг) нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ